



МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалт

ХУУЛЬД ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ХАСХОМ-ИЙГ
МЭДҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛЫН ТАЛААР

Цахим хуудас:

www.iaac.mn, www.ATG.mон
www.meduuleg.iaac.mn
www.xachom.iaac.mn

Харилцах утас:

[70112499](tel:70112499), [70112468](tel:70112468), [70112469](tel:70112469)

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
2016 ОН

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- 2002 он- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр
- 2005 он- Авиалгалын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай хууль
- 2006 он- Авлигын эсрэг хууль
- 2007 он- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- 2011 он- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- 2012 он- Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- 2012 он- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270-р зүйл “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийг нэмж оруулсан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

- Нэгдүгээр бүлэг **Нийтлэг үндэслэл**
- Хоёрдугаар бүлэг **Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан
сэргийлэх**
- Гуравдугаар бүлэг **Албан тушаалтанд тавигдах хориглолт,
хязгаарлалт /12/**
- Дөрөвдүгээр бүлэг **Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг**
- Тавдугаар бүлэг **Хуулийн хэрэгжилтийг хянах**

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

/AC3TX-ийн 7 дугаар зүйл/

- Ашиг сонирхлын зөрчлөөс урьчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх;
- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах;
- Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх;
- Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх;
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх;
- Өөрийн удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэх.

Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

/АЭХ болон АСЗТХ-ийн 4 дүгээр зүйл/

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах няглан бодогч;
- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- олон нийтийн радио, телевизын Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигч;
- бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан.

/энэ зүйлийг 2014 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

Ашиг сонирхлын зөрчил

нийтийн албан тушаалтан
албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед
түүний хувийн ашиг сонирхол нийтийн
ашиг сонирхолтой зөрчилдөх болон
албан үүргээ тэгш, шударгаар
хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж
боловхуйц нөхцөл байдлыг хэлнэ.

Нийтийн ашиг сонирхол

Нийтийн ашиг сонирхол

Нийтийн албан
тушаалтан
Монгол Улсын
Үндсэн хууль, бусад
хуулиар олгогдсон
бүрэн эрхээ хувийн
ашиг сонирхлоосоо
ангид тэгш,
шударгаар
хэрэгжүүлнэ гэх
олон нийтийн
итгэлийг хэлнэ.



Хувийн ашиг сонирхол

Хувийн ashiг сонирхол

Нийтийн албан
тушаалтан албаны
бүрэн эрхээ
хэрэгжүүлэхэд өөрөө
болон түүнтэй
хамаарал бүхий
этгээдийн зүгээс
нэлөөлж болохуйц
эдийн болон эдийн
бус ашиг сонирхлыг;



АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

- 1. Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль,**
- 2. УИХ-ЫН Хууль зүйн байнгын хорооны тогтоол**



➤ Авлигын эсрэг хууль

/2006.07.06-ны өдөр батлагдсан, 2008.05.29, 2012.01.19, 2012.05.18, 2014.01.24-ний өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт орсон./

➤ Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

/2012.01.19-ний өдөр батлагдсан, 2012.05.01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн бөгөөд 2012.03.09, 2012.05.18, 2013.05.31, 2014.01.24-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон./

➤ Монгол улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоол

1. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам

/Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт/

УИХ-ЫН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

МЭДҮҮЛГИЙН МАЯГТУУД

2. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг

/ХЗБХорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/

3. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг

/ХЗБХорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт/

4. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл

/ХЗБХорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт/

5. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт

/ХЗБХорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт/

6. Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг

/ХЗБХорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт/

2. Монгол Улсын Авлигатай тэмцэх газраас батлан гаргасан эрх зүйн баримт бичиг

- **Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт батлах тухай, 6 хавсралттай.** /АТГ-ын 2012.06.13-ны өдрийн 91 дүгээр тушаалаар баталсан./
- **Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам**
/Авлигатай тэмцэх газрын даргын 2012.10.11-ны өдрийн 196 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан./
- **Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам, 4 хавсралттай.** /АТГ-ын 2012.10.11-ны өдрийн 196 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан./

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 2014 ОНЫ 20 ДУГААР ТӨГТООЛ

- Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.
- 2012 оны 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт” шинэчилэгдэн батлагдсан.

“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам“-д орсон нэмэлт, өөрчлөлт

- 2.2.12.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг **хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа** төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт;
- 2.2.13.төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай гэрээ байгуулан төрийн тодорхой чиг үүргийг **түр буюу байнга гүйцэтгэж байгаа** төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан тухайн төсвийн захирагчид /төсвийн шууд захирагчид/;
- 2.2.14.төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх **орон тооны зөвлөх** Улсын Их Хурлын Тамгын газарт;
- 3.9.Албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хувьцаат компанийн нийт хувьцааны **5 хүртэл хувийг** эзэмшдэг бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзнэ.

“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам“-д орсон нэмэлт өөрчлөлт

- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалд томилогдох этгээд, цаашид **тухайн байгууллагын зохион байгуулалтын нэгж дотроо ажлын байрны тодорхойлолт, эрхлэх асуудлын чиг үүрэгт нь өөрчлөлт орсны улмаас шилжүүлэн болон сэлгэн томилох, туршилтын хугацаагаар, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд тухайн албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр мэдүүлэг гаргах албан тушаалд томилохдоо хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч, холбогдох баримт бичгийн хамт Авлигатай тэмцэх газарт нэн даруй хүргүүлнэ.**
- **Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, төрийн албан хаагчийн анкет, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, бусад шаардлагатай баримт бичгийг хавсаргана.**

**“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын
мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-аар
ХАСХОМ-ийг гаргахгүй албан тушаалтнууд**

- шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “TT-1”-“TT-10”-д хамаарах албан тушаалтан болон “TT-11”-ийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс бусад албан тушаалтан;
- батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгууллагын “TT-1”-“TT-8”-д хамаарах албан тушаалтан;
- онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын “TT-1”-“TT-11”-д хамаарах;
- цагдаагийн байгууллагын “TT-1”-“TT-8”-д хамаарах;
- хил хамгаалах байгууллагын “TT-1”-“TT-10”-д хамаарах;
- тагнуулын байгууллагын “TT-1”-“TT-9”-д хамаарах;
- Тахарын албаны “TT-1”-“TT-11”-д хамаарах;
- хууль сахиулагчийг бэлтгэх сургуулийн “TT-1”-“TT-13”-д хамаарах;
- шүүхийн шинжилгээний байгууллагын “TT-1”-“TT-8”-д хамаарах албан тушаалтан болон “TT-9”, “TT-10”-ын шинжээчээс бусад албан тушаалтан;
- Авлигатай тэмцэх газрын туслах ажилтан;

**“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-аар
ХАСХОМ-ийг гаргахгүй албан тушаалтнууд**

- улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх **туслах, бие төлөөлөгч, хэвлэлийн ажилтан**;
- Монгол Улсын Их Хурал дахь болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх **нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан**;
- төрийн захиргааны албаны “ТЗ-1”-“ТЗ-5”-д хамаарах албан тушаалтан;
- төрийн захиргааны албаны “АА-9”-“АА-11”-д хамаарах албан тушаалтан;
- боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний “ТУШУ-4”, “ТУМБ-4”, “ТУМБ-5”, “ТУМБ-6”, “ТҮЭМ-5”, “ТҮСҮ-7”, “ТҮСҮ-8”-д хамаарах албан тушаалтан;
- боловсрол, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших “ТУМБ-7”, “ТУМБ-8”, “ТҮЭМ-6”, “ТҮЭМ-7”-д хамаарах мэргэжлийн албан тушаалтан.

Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албаны “ТҮЭМ-5, удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших “ТҮЭМ-6”, “ТҮЭМ-7”-д хамаарах мэргэжлийн албан тушаалтан

Албан тушаалын ангилал	Зэрэглэл	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал	Удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших мэргэжлийн албан тушаал
Удирдах албан тушаал	ТҮЭМ-9	Улсын эмнэлгийн дарга	-
	ТҮЭМ-8	Улсын эмнэлгийн орлогч дарга	-
	ТҮЭМ-7	-Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн орлогч дарга, -Аймгийн зэрэглэлтэй хотын нэгдсэн эмнэлгийн дарга	-Улсын клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн зөвлөх эмч, -Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн зөвлөх эмч
	ТҮЭМ-6	-Сум, тосгон, сум дундын эмнэлэгийн дарга, -Эмнэлгийн албаны дарга буюу эмнэлгийн чанарын буюу хүний нөөцийн менежер, -Аймгийн зэрэглэлтэй хотын нэгдсэн эмнэлгийн орлогч дарга	-Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлгийн зөвлөх эмч -Улсын клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн тасгийн эрхлэгч
	ТҮЭМ-5	Засгийн газрын 2012.05.02-ны өдрийн 152 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон.	Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдэл, аймгийн зэрэглэлтэй хотын нэгдсэн эмнэлэг, тэдгээртэй адилтгах байгууллагын тасгийн эрхлэгч

**Мэргэжлийн боловсролын салбарын төрийн үйлчилгээний албаны “ТҮМБ-4”,
“ТҮМБ-5”, “ТҮМБ-6”, удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших “ТҮМБ-7”
“ТҮМБ-8”-д хамаарах мэргэжлийн албан тушаалтан**

Албан тушаалын ангилал	Зэрэглэл	Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаал	Удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших мэргэжлийн албан тушаал
Удирдах албан тушаал	ТҮМБ-9	Их сургуулийн захирал	-
	ТҮМБ-8	-Дээд сургуулийн захирал -Их сургуулийн дэд захирал	Магистр, докторын сургалтын профессор
	ТҮМБ-7	-Дээд сургуулийн дэд захирал -Коллежийн захирал -Их сургуулийн факультет, /сургууль/-ийн захирал /декан/ -Их, дээд сургуулийн сургалтын албаны дарга	Магистр, докторын сургалтын дэд профессор
	ТҮМБ-6	-Их, дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч -Коллежийн сургалтын албаны дарга -Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн захирал	-Магистр, докторын сургалтын албаны дарга, ахлах багш -Бакалаврын сургалтын профессор
	ТҮМБ-5	-Коллежийн тэнхимийн эрхлэгч -Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн дэд захирал	-Магистр, докторын сургалтын багш -Бакалаврын сургалтын дэд профессор
	ТҮМБ-4	Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын менежер	Бакалаврын сургалтын ахлах багш

Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албаны “ТҮШУ-4”-д хамаарах мэргэжлийн албан тушаалтан

Албан тушаалтын ангилал	Зэрэглэл	Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаал	Удирдах албан тушаалтай дүйцүүлэн жишиг мэргэжлийн албан тушаал
Удирдах албан тушаал	ТҮШУ-4	<ul style="list-style-type: none">Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргаЭрдэм шинжилгээний хүрээлэнгийн сектор, лабораторийн эрхлэгчШинжлэх ухааны академийн хэлтсийн дарга	
	ТҮШУ 5-7	<i>Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтанд хамаарна.</i>	

Мэдүүлэг гаргагчийн тухай

төрийн улс төрийн,
захиргааны, тусгай
албаны удирдах болон
гүйцэтгэх албан
тушаалтан

төрийн үйлчилгээний
албаны удирдах албан
тушаалтан болон
ерэнхий, ахлах нягтлан
бодогч

төрийн болон орон нутгийн
өмчит, төрийн болон орон
нутгийн өмчийн
оролцоотой хуулийн
этгээдийн удирдах болон
компанийн эрх бүхий
албан тушаалтан

улсын болон орон нутгийн
төсвөөс санхүүжилт авч төрийн
тодорхой чиг үүргийг хууль
тогтоомжийн дагуу гүйцэтгэж
байгаа төрийн бус
байгууллагын удирдах албан
тушаалтан

МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ

Бүх шатны иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын
дарга, төлөөлөгч

Эрх бүхий байгууллагаас
баталсан жагсаалтад орсон
албан тушаалтан

ТӨРИЙН ӨНДӨР БЮОУ ТҮҮНТЭЙ АДИЛГАХ АЛБАН ТУШААЛТАН МЭДҮҮЛГЭЭ ХААНА ГАРГАХ ТАЛААР

Монгол Улсын Ерөнхийлөгч

Улсын Их Хурлын
дарга, дэд дарга, гишүүн

Ерөнхий сайд, Засгийн
газрын гишүүн, сайд нар

Улсын ерөнхий
прокурор, түүний орлогч

Монгол банкны
Ерөнхийлөгч, тэргүүн
дэд, дэд ерөнхийлөгч

Үндэсний аюулгүй байдлын
зөвлөлийн нарийн бичгийн
дарга

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн Тамгын
газрын дарга

Улсын Их Хурлын Тамгын
газрын Ерөнхий нарийн
бичгийн дарга

Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дэд дарга

Санхүүгийн зохицуулах
хорооны дарга,
гишүүн, Хяналтын
зөвлөлийн дарга, гишүүн

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Засгийн газрын
агентлагийн дарга

Засгийн газрын бүрэн эрхт
төлөөлөгч

Монгол улсын
Ерөнхийлөгч, Улсын Их
Хурал, Засгийн газар,
Ерөнхий сайдаас
томилогддог бусад албан
тушаалтан

Төрийн албаны зөвлөлийн
дарга, гишүүн

Ерөнхий аудитор, түүний
орлогч болон Үндэсний
статистикийн хорооны дарга

Яамны төрийн нарийн
бичгийн дарга

Шүүхийн ерөнхий
зөвлөлийн дарга, гишүүн

Хүний эрхийн үндэсний
комиссион дарга, гишүүн

Сонгуулийн ерөнхий
хорооны дарга, нарийн
бичгийн дарга

Олон нийтийн радио,
телевизийн Үндэсний
зөвлөлийн дарга, Ерөнхий
захирал

Шүүхийн Ерөнхий зөвлөлд

Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч

УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд

Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан

УИХ-ын Тамгын газарт

төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх [/УИХ-ын ХЗБХ-ны 20-р тогтоолоор/](#)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан [/ХЗБХ 20-р тогтоолоор/](#)

төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, банк, санхүүгийн байгууллага, биржийн удирдах албан тушаалтан

Төрийн өмчийн хороонд

Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан

**түүнийг
томилсон,
эсвэл удирдах
эрх бүхий
албан
тушаалтанд**

Төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албаны дарга, захирал, эрхлэгч, тэдгээртэй адилтгах албан тушаалтан

Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусlamжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан

Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан

Эрдэм шинжилгээ, инноваци, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг эрдэм шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтан

яам, агентлагын дэргэдэх өөрийгөө санхүүжүүлдэг салбар, нэгжийн удирдах албан тушаалтан

Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан жагсаалтад орсон албан тушаалтан

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНД**

Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, төлөөлөгч, ажлын албаны ажилтан, Засаг дарга, Засаг даргын орлогч

**СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН
АЖЛЫН АЛБАНД**

Сум, дүүргийн ИТХ-ын дарга, төлөөлөгч, ажлын албаны ажилтан, Засаг дарга, Засаг даргын орлогч, баг, хорооны Засаг дарга

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЗДТГ-т**

аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас томилогддог төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалтан

орон нутгийн өмчйт болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал

ТӨСВИЙН ЗАХИРАГЧИД
/төсвийн шууд захирагчид/

төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан */УИХ-ЫН ХЗБХ-НЫ 20-Р ТОГТООЛООР/*

МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

Авлигын
талаар
мэдээлэх

Хөрөнгө, орлого,
зээлийг үнэн зөв
мэдүүлэх

Эх үүсвэрээ
бодитой, үнэн зөв
тайлбарлах

Мэдүүлгийг
хуулийн заасан
хугацаанд гаргах

ХАСЗ-гүй, зөрчил
үүссэн тухай
мэдэгдлийг гаргах

Жил бүрийн 2 дугаар
сарын 15-ны дотор

Албан тушаалд
томилогдсон буюу
сонгогдсон өдрөөс
хойш 30 хоногт

Мэдүүлэгт их
хэмжээний өөрчлөлт
орсон тухай бүр 30
хоногийн дотор

Мэдүүлгийг хянан шалгах

Авлигатай
тэмцэх газар

Өргөдөл, гомдол,
мэдээллийн мөрөөр

Төлөвлөгөөт хяналт
шалгалтаар

Хугацаанд нь гаргаж
өгөөгүй

Эх үүсвэрийг
заагаагүй

Бодитой, үнэн зөв
тайлбарлаагүй

Хөрөнгө, орлогыг
хэрхэн олсоноо
тайлбарлаагүй

албан тушаалтны
мэдүүлгийг хянан
шалгана.

ЭБАТ нь мэдүүлэгт хяналт тавьж, гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн
гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу
Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

ХАСХОМ-ийн зөрчилд хүлээлгэх хариуцлага /АЭХ-13.8/

Сануулах

1 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн

хугацаа хожимдуулсан нь хүндэтгэх шалтгаантай бол

Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл 30 хувиар бууруулах

6 хүртэл сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн

удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан

Албан тушаал бууруулах, мөн цалин бууруулах

6 сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн

Нийтийн албанаас халах

1 жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, буюу худал мэдүүлсэн

эсхүл гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан

Ашиг сонирхлын зөрчилд хүлээлгэх хариуцлага /СЗТХ-ийн 29.2/

Хариуцлагын төрлүүд:

- сануулах
- цалинг тодорхой хэмжээгээр бууруулах
- мөнгөн торгууль ногдуулах
- хууль бус үйл ажиллагааг нь хүчингүй болгох
- албан тушаал бууруулах
- нийтийн албанаас халах

МЭДҮҮЛГИЙН ТӨРӨЛ

**Хувийн ашиг
сонирхлын
УРЬДЧИЛСАН
МЭДҮҮЛЭГ**

- Нийтийн албанд томилогдооор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч АТГ-т хүргүүлнэ, АТГ ажлын 10 хоногт багтаан хянаж, хариу хүргүүлнэ.

**Хувийн ашиг сонирхлын
болон хөрөнгө орлогын
мэдүүлэг
ХАСХОМ**

- Шинээр томилогдсон, сонгогдсон
- Шинэчилэн гаргасан
- Их хэмжээний өөрчлөлтийг
мэдүүлсэн

**Хувийн ашиг
сонирхлын зөрчилгүй
гэдгээ илэрхийлэх,
зөрчил үүссэн тухай
мэдэгдэл, тайлбар**

- Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй



Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэс болон хөрөнгө, орлогын мэдүүлэс

Мэдүүлгийн цахим системийн талаар

Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс



Монгол Улсын Авлигатай Тэмцэх Газар
ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ
Мэдүүлгийн Бүрдүүлэлтийн Програм

Т.Дэлгэрням та тавтай морил

Үндсэн үйлдэл

Мэдээ мэдээлэл

ХАСХОМ-ын тайлан

ХАСХОМ

ЭБАТ

Судалгаа шинжилгээний програм

Олон нийт

**“AIDIS” цахим систем програм нь нийт мэдүүлэг гаргагч,
хэрэглэгчид зориулан хийгдсэн.**

Энэхүү програм нь дараах давуу нөхцлийг бүрдүүлнэ.

- ✓ Албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;
- ✓ Мэдүүлгийг гаргах ажиллагааг шуурхай зохион байгуулах;
- ✓ Олон нийтэд төрийн өндөр албан тушаалтны мэдээллийг журмын дагуу шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх;
- ✓ Мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн сүүлийн 3 жилийн мэдээллийг харьцуулах;
- ✓ Интенэт орчин бүхий нөхцөлд мэдүүлгээ хаанаас ч гаргах;
- ✓ Урьд онуудын мэдүүлэгтэйгээ танилцах, мэдүүлгээ жил бүр шинэчлэн бүртгүүлэх.

Хөрөнгө орлогын мэдүүлгийн систем

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн бүтэц

- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээллийн систем



www.meduuleg.iaac.mn

- Хөрөнгө орлогын мэдүүлгийн систем
Судалгаа шинжилгээний програм




www.xachom.iaac.mn

- Төрийн өндөр албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг олон нийтэд нээлттэй мэдээллэх

- Хөрөнгө орлогын мэдүүлгийн системийн урдирдлагын програм

Хөрөнгө орлогын мэдүүлгийн системд хандахаа

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлэхдээ / meduuleg.iaac.mn / цахим хаягаар хандана



Хөрөнгө орлогын мэдүүлгийн системийн нэвтрэх хуудас

Нэвтрэх форм

invalid certificate
thawte

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм

Нэвтрэх нэр

Нууц үт

[Нууц уг сэргээх холбоос](#)

Нэвтрэх Арилгах

???????

Цахимд бүртгэлтэй **Имэйл**
хаягаа бичнэ


Цахимд бүртгүүлсэн
Имэйл хягаар ирсэн **нууц**
ҮГ

Анхаарах

- Эрх бүхий албан тушаалтан цахимд дараах 2 төрлийн “**Имэйл хаяг**” бүртгүүлнэ.
 - Мэдүүлэг гаргагчийн имэйл хаяг
 - Байгууллагын эрх бүхий албан тушаалтаны эрхээр нэвтрэх имэйл хаяг


ЭБАТ –ны **/и-мэйл/** хаяг ашиглагдахгүй болсон бол төв байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд баталгаатай **/и-мэйл/** хаягыг өгч засварлуулна.

Хөрөнгө орлогын мэдүүлгийн системд нэвтрэх “Нууц үг” -сэргээх



- системд нэвтрэх “Нууц үг” -ийг мартсан бол “Нууц үг сэргээх холбоос” руу орно.

ЦАХИМ СИСТЕМД АНХААРАХ АСУУДАЛ /И-МЭЙЛ ХАЯГ/



- Нууц үг сэргээхэд и-мэйл хаягаар нь код ирэхгүй байгаа асуудал үүсдэг ба энэ нь дараах шалтгаанаас болдог.
 1. И-мэйл хаяг нь буруу
 2. И-мэйл очсон боловч **Spam**-д орсон,
 3. И-мэйл хаяг нь блоклогдсон, гаднаас мэйл авахгүй байгаа
 4. И-мэйл сервер ажиллахгүй болох /зарим тохиолдолд/

Төрийн өндөр албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг олон нийтэд нээлттэй мэдээллэх

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Авлигатай тэмцэж, шударга ёсиг тогтоон, нөгжил дэвшилд күргэнэ

Эхлэл ХОМ харах Гомдол оруулах Санаал оруулах Тусламж

Авлага үгүй болсоор
Бид эрүүл хөгжлийн нийтийг бутээн босноо.



АВЛИГА
ТӨРИЙН ҮГҮЙ ЧУХАЛ

Авлигатай тэмцэх газрын олон нийтийн цахим хуудсанд тавтай морилно уу
Авлигын эсрэг хуулийн 14 дугээр зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх

Нүүр хуудас

- Мэдээ, мэдээлэл
- Хууль тогтоомж, журам
- Сүүлийн 5 жилийн мэдүүлэг

Холбоосууд

- АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
- Цахим мэдүүлэл
- МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛОГЧ
- МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
- МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

дарга, гишүүн;

14.1.Дараахь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хэвлэн нийтлэх ба цахим мэдээллийн сүлжээнд байрлуулна:

14.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;
14.1.2.Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;
14.1.3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;
14.1.4.Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний орлогч, гишүүн;
14.1.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;

14.1.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;
14.1.7.Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч;
14.1.8.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
14.1.9.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга;
14.1.10.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;

14.1.11.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
14.1.12.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга;

14.1.13.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;

14.1.14.Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;
14.1.15.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;

14.1.16.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;

14.1.17.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;

14.1.18.Барийн түүчин, түүчин орлогч.

Статистик Их сэтгэдэл Их уншсан

Нийт 722 хөрөнгө, орлогын мэдүүлэг байна

Яг одоо 2 зочин байна

Өнөөдөр нийт 4 удава хандсан

Энэ долоо хоногт нийт 64 удаа хандсан

2013.05.06 эхэлж нийт 36511 удаа хандсан

Та Авлигын эсрэг хуулийн үйлчилд хамаарах бүх мэдүүлэг гаргагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг олон нийтэд ил болгож энзхуу цахим хуудсанд байршуулахыг дэмжиж байна уу.



ХАСХОМ-ийг заргахад анхаарах асуудлын тухайд



ЗАГВАР ЖИШЭЭ



Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

- Мэдүүлэг гаргагч
- Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн гишүүд

Хувийн ашиг сонирхол:

- Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд
- Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд
- Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн
- Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал
- Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт
- Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал
- 2.7-д гарын үсгээ зурах.

Хөрөнгө, орлого, зээл:

- Орлого
- Хөрөнгө, зээл:
 - Орон сууц, барилга байгууламж
 - Тээврийн хэрэгсэл
 - Мал аж ахуй
 - Газар
 - Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл
 - Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэгдэл
 - Авлага
 - Зээл
 - Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт
 - Эрх, патент, тусгай зөвшөөрөл

АЛБАН ТУШААЛТНЫ 2015 ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

1.1. Мэдүүлэг гаргагч:																					
Ургийн овог: Сартуул				Эцэг/эхийн нэр: Доной				Нэр: Дашдорж													
Регистерийн дугаар:										Иргэний үнэмлэхийн дугаар:											
<table border="1"><tr><td>A</td><td>Ю</td><td>7</td><td>1</td><td>1</td><td>1</td><td>1</td><td>6</td><td>7</td><td>0</td></tr></table>										A	Ю	7	1	1	1	1	6	7	0		
A	Ю	7	1	1	1	1	6	7	0												
Оршин суугаа газрын хаяг: БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот										Гар утас: 9999-9999 Ажлын утас: 70112555 Гэрийн утас: 21242469	Цахим шуудангийн хаяг: Bayar_99@gmail.com										
Боловсрол, мэргэжил: Дээд, эрх зүйч										Байгууллагын нэр: БХБЯ /Барилга, хот байгуулалтын яам/											
Төрсөн газар: Завхан, Түдэвтэй сумын төрөх тасаг										Газар, хэлтэс, тасаг, алба: ГХГЗЗГ /Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар/											
Үндсэн харьяа: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг										Албан тушаал: Ахлах мэргэжилтэн											
Сүүлийн хоёр жил ажилласан байгууллага, албан тушаал: Авто замын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн																					
Мэдүүлэг гаргах үндэслэл: <input checked="" type="checkbox"/> тэмдэглэгээ хийнэ. Шинээр томилогдсон, Сонгогдсон <input checked="" type="checkbox"/> Шинэчлэн гаргасан <input checked="" type="checkbox"/> Их хэмжээний өөрчлөлт										Тухайн албан тушаалд томилогдсон, сонгогдсон огноо: 2015 он 12 сар 05 өдөр											

Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал					
Гэр бүлийн байдал	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистерийн дугаар	Төрсөн газар, үндсэн харьяа	Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Ажиллаж байгаа байгуулага, сурч байгаа сургууль, оршин суугаа газрын хаяг
Эхнэр, нөхөр, хамтран амьдрагч	Очирбат Энхцэцэг	Ш372060120	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр төрөх, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг	“XXX” ХХК-ийн өрөнхий захирал	Ажлын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Маргад центр 545 тоот. Гэрийн хаяг: Баянгол дүүрэг, 5 дугаар хороо, 10 дугаар хорооллын 9А байр, 251 тоот.
Хүүхэд	Баяр Тэмүүлэн	УХ94041210	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхас эрдэм шинжилгээний төв	ОХУ-ын Нисэхийн дээд сургуульд оюутан	Баянгол дүүрэг, 5 дугаар хороо, 10 дугаар хорооллын 9А байр, 251 тоот.
	Баяр Хүслэн	УХ06291020	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхас эрдэм шинжилгээний төв	Баянгол дүүргийн 13-р дунд сургуульд сурагч	Баянгол дүүрэг, 5 дугаар хороо, 10 дугаар хорооллын 9А байр, 251 тоот.
Эцэг	--	--	--	--	--
Эх	--	--	--	--	--

Тайлбар: Хамт амьдарч байгаа болон зөвхөн тухайн өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, бусад гишүүдийг бичнэ.

Хоёр. Хувийн ашиг сонирхол:

2.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд

Эцэг /эх/-ийн нэр, нэр	Ямар хамааралтай болох	Ажиллаж байгаа \байсан\ байгууллага, албан тушаал	Бизнес, үйл ажиллагааны чиглэл	Төрсөн газар, үндсэн харьяа
Гомбосүрэн Батцэцэг	Эх	Тэтгэвэрт	-	Завхан аймаг, Тосонцэнгэл сум. Архангай аймаг, Эрдэнэбулагн сум.
Гаадан Очирбат	Хадам эцэг	“AAA” ХХК-ийн ерөнхий захирал	Барилга, зам гүүр	Булган аймаг, Булган сум. Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг.
Эрдэнэбат Цэцэгмаа	Хадам эх	Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан. 2010 онд тэтгэвэрт гарсан.	-	Төв аймаг, Эрдэнэсант сум. Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг.
Дорж Баярсайхан	Ах	Цөмийн энергийн газарт мэргэжилтэн	Нийтийн алба	Архангай аймаг, Эрдэнэбулагн сум. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг.
Дорж Баяртүвшин	Дүү	2010-2012 онд Соёл урлагийн хороонд мэргэжилтнээр ажиллаж байсан, одоогоор ажилгүй.	-	Архангай аймаг, Эрдэнэбулагн сум. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг.
Очирбат Гэрэл	Эхнэрийн эгч	Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж амьдардаг.	БНСУ-д оёдлын үйлдвэр.	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Очирбат Бат	Эхнэрийн дүү	МУИС-н Хууль зүйн сургуульд оюутан.	Боловсрол	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг

Тайлбар: “Хамаарал бүхий этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг хэлнэ.

Хувийн ашиг сонирхол

2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд				
Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай /байсан/ болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Байгууллага. ажил, албан тушаал /Эрхэлж байгаа /байсан/ үйл ажиллагааны төрөл/	Тайлбар
“XXX “ ХХК	Хувь эзэмшигч, үүсгэн байгуулагч	Гадаад, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэл	--	2006 онд эхнэрийн хамтаар үүсгэн байгуулсан.
О.Бат	Эхнэрийн дүү	--	Япон улсаас хамтарч автомашин импортоор оруулж ашиг олдог.	2010 оноос эхлэн одоог хүртэл хамтарч ажиллаж байна.
Д.Чулуун	Найз	--	Өлзийт хороололд хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьж борлуулдаг.	2008 оноос эхлэн одоог хүртэл хамтарч ажиллаж байна.

Тайлбар: “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

2.3. Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн

№	Хаана, ямар байгууллагад харьяалалтай болох	Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Тайлбар
1	Улаанбаатар хот дахь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутгийн зөвлөл	Гишүүн	Орон нутгийг хөгжүүлэх	2010 онд зөвлөлийн гишүүн болсон.
2	Монголын Хөл бөмбөгийн холбоо	Удирдах зөвлөлийн гишүүн	Спортыг хөгжүүлэх	2011 онд гишүүнээр сонгогдсон.

Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.

2.4. Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Төлөөллийг хаана, хэзээ, хэрхэн хэрэгжүүлсэн	Тайлбар
1	Төрсөн ах Д.Баярсайхан	--	2012 онд төрсөн ах Д.Баярсайханы өмчлөлийн орон сууцыг худалдан борлуулахад гэрээ байгуулан итгэмжлэлээр төлөөлсөн	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Шинэ өглөө хотхоны 503 тоот 3 өрөө орон сууцыг авсан.

Тайлбар: Хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ.

Хувийн ашиг сонирхол

2.5. Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт

№	Эх сурвалжийн нэр, хаяг	Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлалын төрөл	Хандив, туслалцаа, хөнгөлөлтийн зориулалт	Үнэлгээ /төгрөг/	Тайлбар
1	Эцэг М.Дорж	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот орон сууцыг өв залгамжлалаар 2015 онд шилжүүлсэн.	--	80,000,000.00	Эцэг М.Доржоос өв залгамжлалаар авсан
2	Авто тээврийн газар	Байгууллагаас туслалцаа үзүүлсэн. Мөнгийг дансаар шилжүүлсэн.	Орон сууцны нөхцөл сайжруулахаар	5,000,000.00	Орон сууцны нөхцөл сайжруулахаар 2015 онд өгсөн.
	Нийт дүн			85,000,000.00	

Тайлбар: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ авсныг бичнэ. Хууль ёсны өв залгамжлалаар хүлээн авсан буюу авах хөрөнгийн талаар мэдүүлнэ.

Хувийн ашиг сонирхол

2.6. Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал

№	Мэдүүлэг, мэдэгдлийн нэр	Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хэзээ, хаана, хэнд гаргасан /Байгууллага, албан тушаалтан/	Гаргах болсон шалтгаан, нөхцөл	Товч утга
1	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл	Авто замын газрын Хуулийн зөвлөх /ЭБАТ/ Д.Намсрайжавт 2015.06.30	Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахаа гаргасан.	Авто замын газраас зарласан тендерт үнэлгээний хорооны гишүүнээр оролцохдоо ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн.
2	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг	Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд 2015.09.20-ны өдөр гаргасан	Нийтийн албанда томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан.	Хувийн ашиг сонирхлын байдлыг мэдүүлсэн

2.7. Албан тушаалын бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашиглахгүйг мэдэгдье.

Гарын үсэг:

D.Баяр

/гарын үсэг/

/ Д.Баяр /

/гарын үсгийн тайлал/

Тайлбар: Нийтийн албанда томилогдохоор нэр дэвшихдээ /тухайн онд/ хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулсан болон мэдэгдэл, тайлбар гаргасан эсэх талаар бичнэ.

Гурав. Хөрөнгө, орлого, зээл:

3.1. Орлого				/төгрөгөөр/
№	Орлогын төрөл	Орлогын дүн		Орлогын эх үүсвэр
		өөрийн	гэр бүлийн гишүүний	
1	Үндсэн цалин, хөдөлмөрийн хэлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	9 024 856	15 650 273	Цалингийн орлого
2	Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого /албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал/	720 850	-	Жилийн үр дүнгийн шагнал
3	Үйл ажиллагааны орлого /үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого/	8 250 000	-	Жимс, хүнсний ногоо борлуулсан орлого
4	Хөрөнгийн орлого /турээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглувалсны орлого/	2 234 561	-	Хадгаламжийн хүүгийн орлого
		-	7 200 000	Илүү байрны түрэсийн орлого
		15 000 000	15 000 000	“XXX” ХХК-ний 2011 оны ногдол ашиг

Хөрөнгө, орлого:

3.1. Орлого				/төгрөгөөр/
№	Орлогын төрөл	Орлогын дүн		Орлогын эх үүсвэр
		Өөрийн	гэр бүлийн гишүүний	
5	Хөрөнгө борлуулсны орлого /Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого/	300 000	-	“TTT” ХК-ны 500 ш хувьцаа борлуулсан
		-	35 265 000	Япон улсад үйлдвэрлэгдсэн Ниссан Тийда, Тоёота Гранд Марк 2, Тоёота Витз маркийн (номергүй) машиныг борлуулсан.
		3 600 000	-	30 толгой хонь борлуулсан.
6	Хандивын орлого /бусдаас авсан мөнгөн хандив, тусламж/	2 000 000	-	Орон сууцны нөхцөл сайжруулах
7	Бусад орлого /шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тогтолц зохион байгуулах, тэдгээрт оролцо замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого /	6 120 000	-	Малын ашиг шимиин орлого (ноолуур, мах)
		-	2 514 000	БНСУ-д ажилладаг хадам эгчээс 2000 ам.доллар өгсөн
		924 350	-	2015 онд орон сууц худалдан авсны татварын буцаан олголт
		-	120 000	Хүүхдийн мөнгө
		126 000	378 000	Эх орны хишиг
8	Нийт дүн	48 300 617	76 127 273	

Тайлбар: Жилийн хугацаанд олсон орлогыг дээрх орлогуудын төрөл тус бүрээр үнэн зөв мэдүүлнэ.

3.2. Хөрөнгө, зээл

▫ Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.1. Орон сууц, барилга, байгууламж						
№	Орон сууц, барилга, байгууламжийн төрөл	Хийц, талбай	Байршил /хаяг/	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Бүртгэлийн гэрчилгээний дугаар	Эх үүсвэрийн тайлбар
1	Нийтийн орон сууц	Угсармал, 60 м ² , 3 өрөө	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот	80 000 000	Ү-2204689721	2015 онд эцэг М.Доржоос өв залгамжлалаар авсан. Өмчлөгч Д.Баяр
2	Авто гараж	Тоосгон, 12 м ²	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны дэргэд	10 000 000	Гэрчилгээ гараагүй	2012 онд 5 сая төгрөгөөр худалдаж авсан, Хьюндэй Соната-2 маркийн машин зарсан орлогоор авсан.
3	Зуслангийн байр	Палкан, 60 м ² , mansard бүхий	Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан 5 дугаар буудал /хуучнаар авто баазын ажилчдын зуслан/	25 000 000	Үл хөдлөхийн гэрчилгээ гараагүй	2010-2012 онд 15 сая төгрөгийн өртөгтэйгээр өөрсдөө барьсан. Тухайн үед 10 сая төгрөгийн зээл авсан, үлдсэн мөнгийг гэр булийн гишүүдийн цалин, хуримтлал, компанийн ногдол ашгийн орлогоор бий болгосон.

Хөрөнгө, зээл

▫ Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.1. Орон сууц, барилга, байгууламж

№	Орон сууц, барилга, байгууламжийн төрөл	Хийц, талбай	Байршил /хаяг/	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Бүртгэлийн гэрчилгээний дугаар	Эх үүсвэрийн тайлбар
4	Нийтийн орон сууц	Төмөр бетонон цутгамал, 34 м ² , 1 өрөө	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Өнөр хотхоны 10 дугаар байрны 65 тоот	40 000 000	Y-2203512689	2011 онд 40 сая төгрөгөөр худалдаж авсан. Эх үүсвэр нь Орон сууц санхүүжилтийн корпорацаас 35 сая төгрөг, үлдсэн 5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор бий болгосон. Эхнэр хадам эцэг, эхийн дундын өмчлөл.
5	Авто зогсоол	15 м ²	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Өнөр хотхоны 10 дугаар байрны зоорийн давхарт 15 тоот зогсоол	24 000 000	Y-22016582568	Японоос оруулж ирсэн машин зарсан орлогоор 2012 онд 10 сая төгрөгөөр худалдаж авсан.
Нийт дүн			169 000 000			

Тайлбар: “Орон сууц, барилга, байгууламжийн төрөл” хэсэгт хувийн, нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр болон гэр зэргийг мэдүүлнэ. “Хийц, талбай” баганад тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээ, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ.

Хөрөнгө, зээл

¤ Тээврийн хэрэгсэл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.2. Тээврийн хэрэгсэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл, үйлдвэрлэсэн он	Тоо, ширхэг	Гэрчилгээ, улсын дугаар, эзэмшигчийн нэр	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар
1	Тоёота Клюгер, 2010 онд үйлдвэрлэгдсэн	1 ш	АЯ123456, УНП 12-34, Д.Баяр	21 000 000	2014 онд 18 сая төгрөгөөр худалдаж авсан. ХААН банкны хадгаламжаас 2 сая төгрөг, “XXX” ХХК-ын ногдол ашгаас 5 сая төгрөг, урьд нь хэрэглэж байсан Гранд Марк-2 маркийн УБӨ 23-45 дугаартай машиныг борлуулсан 8 сая төгрөгөөр эх үүсвэрийг бий болгосон.
2	Тоёота Приус, 2013 онд үйлдвэрлэгдсэн	1 ш	АЯ654321, УБП 34-56, О.Энхцэцэг	9 000 000	2013 онд 8 сая төгрөгөөр хадам эцэг, эх эхнэр О.Энхцэцэгт худалдаж авч өгсөн.
Нийт дүн				30 000 000	

Тайлбар: “Тээврийн хэрэгсэл” хэсэгт автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ.

Хөрөнгө, зээл

▫ Мал, аж ахуй байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

4.2.3 Мал, аж ахуй

№	Төрөл	Тоо, толгой	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар	Байршил
1	Хонь	130	21 340 000	Өвөө Н.Мягмараас 2012 онд тасалж өгсөн 20 хонь, төлөөр өссөн.	Завхан аймгийн Түдэвтэй сум, нагац ах М.Рагчаагийн байдаг
2	Ямаа	115	17 650 000	Өвөө Н.Мягмараас 2012 онд тасалж өгсөн 20 ямаа, төлөөр өссөн.	Завхан аймгийн Түдэвтэй сум, нагац ах М.Рагчаагийн байдаг
3	Адуу	19	15 700 000	Аав М.Доржоос 2012 онд 5 адuu тасалж өгсөн, 2013 онд Хэнтий аймгаас 3 унагатай гүүг 3 сая төгрөгийн хуримтлалын орлогоор худалдаж авсан, төлөөр өссөн.	Завхан аймгийн Их-Уул сум, найз Д.Содовынд байдаг
4	Хурдан удмын адуу	5	5 000 000	Нутгийн найз нөхдөөс бэлэглэсэн.	Завхан аймгийн Их-Уул сум, найз Д.Содовынд байдаг
Нийт дүн		269	59 690 000		

Тайлбар: “Мал, аж ахуй” хэсэгт таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлээр үргүүлж байгаа гахай, тахиа, зөгий, шувуу, бусад гэрийн тэжээвэр амьтдыг мэдүүлнэ.

Хөрөнгө, зээл

¤ Газар байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.4 Газар

№	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дугаар, он, сар, өдөр	Төрөл, хэмжээ	Байршил /бүс нутаг/, хаяг	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар
1	ГД:987654, 2009.10.24-ны өдрийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 358 дугаартай захирамжаар	Эзэмших эрхтэй, 0,04 га	Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан	5 000 000	2009 онд улсаас хууль журмын дагуу авсан.
2	ГД:123456, 2013.12.19-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын 147 дугаартай захирамжаар	Өмчлөх эрхтэй, 0,07 га	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Тахилтын аманд	5 000 000	2013 онд цалин, хуримтлалын орлогоор 3 000 000 төгрөгөөр худалдаж авсан.
3	2014.10.24-ны өдрийн Баянгол дүүргийн Засаг даргын 322 дугаартай захирамжаар	Ашиглах эрхтэй, 12м2	Баянгол дүүргийн 5-р хороо 10-р хороолол 9А байрны дэргэд	--	Гэрээгээр түр ашиглаж байгаа
Нийт дүн				10 000 000	

Тайлбар: Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа болон ашиглаж байгаа газрыг мэдүүлнэ.



Хөрөнгө, зээл

- Үнэт эдлэл, урлагийн бүтээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.5 Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл

№	Хөрөнгийн нэр	Үнэлгээ /төгрөг/	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн болон бусад тайлбар
1	Шүрэн толгойтой халтар манан хөөрөг	20 000 000	Д.Баяр	Өвөө Н.Мягмаржаваас 2009 онд өвлөж авсан.
2	Мөнгөн тооногтой хуучны эмээл хазаар	10 000 000	Б.Тэмүүлэн	Эцэг М.Доржоос ач хүү Б.Тэмүүлэнд 2015 онд өв залгамжлалаар шилжүүлсэн.
Нийт дүн		30 000 000		



Хөрөнгө, зээл

▫ Хадгаламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.6 Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэдэл

№	Банк, санхүүгийн байгууллагын нэр	Дүн төгрөг/	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн тайлбар
1	Худалдаа хөгжлийн банкны хугацаатай хадгаламж	26 657 500	О.Энхцэцэг, Д.Баяр, Б.Тэмүүлэн, Б.Хүслэн	2014 онд 3 сая төгрөгөөр хугацаагүй хадгаламжийн данс нээлгэсэн. Цалин, хуримтлалын орлого, хөрөнгө борлуулсны орлого, “XXX” ХХК-ийн ногдол ашгийг хадгалуулсан мөнгө
2	Худалдаа хөгжлийн банкны цалингийн карт	237 000	Д.Баяр	Цалингийн орлого
3	Хаан банкин дахь хувийн харилцах данс	2 345 000	О.Энхцэцэг	Үйл ажиллагааны орлого, өдөр тутмын гүйлгээ хийгддэг.
4	Бэлэн мөнгө	680 000	О.Энхцэцэг, Д.Баяр	Цалин, үйл ажиллагааны орлогын 2015.12.31-ны өдрийн үлдэгдэл
	Нийт дүн	29 899 500		

Тайлбар: Гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн хадгаламж болон данс, картны үлдэгдэл, бэлэн мөнгө, түүнийг эзэмшигчийн талаар мэдүүлнэ.

Хөрөнгө, зээл

▫ Авлага байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.7 Авлага

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Дүн /төгрөг/	Хугацаа, хүү	Тайлбар
1.	Д.Батдорж	45 000 000	Сарын 0.8 хувийн хүйтэй	Өрхийн үйлдвэрлэл явуулахаар зээлж авсан.
	Нийт дүн	45 000 000		

▫ Зээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.8 Зээл

№	Зээлдүүлэгчийн нэр, хаяг	Анх авсан зээлийн хэмжээ /төгрөг/	Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн дүн /төгрөг/	Зээл авсан, болон төлж дуусах огноо	Зориулалт	Зээлийн байрьцаа, батлан даагч
1	Орон сууц санхүүжилтийн корпораци	35 000 000	4 236 890	2011.07.20 - 2021.07.20	Орон сууц худалдан авах	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Өнөр хотхоны 10 дугаар байрны 65 тоот
	Нийт дүн	35 000 000				

Хөрөнгө, зээл

▫ Хөрөнгө оруулалт байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.9 Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт

№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нэгж хувьцааны үнэ /төгрөг/	Хувьцааг худалдаж авсан үнэ /төгрөг/	Хуулийн этгээдийн дурмийн сан /төгрөг/	Ногдо л хувь	Эх үүсвэрийн тайлбар
1	“XXX” ХХК	1000 ш	-	-	1 000 000	100%	2006 онд эхнэрийн хамт үүсгэн байгуулсан. О.Энхцэцэг 50%-ийг, Д.Баяр 50%-ийг тус тус эзэмшдэг.
2	“Эрдэнэс таван толгой” ХК	4288 ш	-	-	-	-	Улсаас гэр бүлийн 4 гишүүнд үнэгүй өгсөн. /Энгийн хувьцаа/
3	“Эрдэнэс МГЛ” ХХК	4 ш	-	-	-	-	Улсаас гэр бүлийн 4 гишүүнд үнэгүй өгсөн. /Давуу эрхийн хувьцаа/
4	“Их дэлгүүр” ХК	148 ш	568	-	-	-	1992 онд цэнхэр тасалбараар улсаас үнэгүй өгсөн.
	Нийт дүн				1 000 000		

Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн
этгээд, толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн
биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг мэдүүлнэ. Компани, бусад хуулийн этгээд
байгуулсан хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ.

Хөрөнгө, зээл

¤ Эрх, патент, тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.10 Эрх, патент, тусгай зөвшөөрөл

№	Төрөл	Эзэмшигчийн нэр	Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага, огноо	Тайлбар
1	Зохиогчийн эрх	Д.Баяр	Оюуны өмчийн газар, 2013 он	“Ухаарлын хишиг” ном бичиж зохиогчийн эрх авсан.

Тайлбар: **Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ.**

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн:

D.Баяр

/гарын үсэг/

/ Д.Баяр /

/гарын үсгийн тайлал/

2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр



АНХААРАЛ ТАВЬСАНД

БАЯРЛАЛАА

